



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/297

Арвайхээр


┌ Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод ┐
 зарцуулах эрх олгох тухай

Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4.2-т заасныг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг зарцуулах хүсэлт ирүүлсэн байгууллагуудын материалыг хянан хавсралтаар баталж журмын дагуу эрх олгосугай.

2.Орлогын дүнд багтаан зарцуулах эрхийг олгон, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100652